

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны
 12 дугаар сарын 22-ны өдрийн 43/1 дүгээр албан
 бичгийн нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 22

Улаанбаатар хот

№	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин (2020 он)	Зорилтод түвшин			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
									ХШҮШҮ 2023 он Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв /сая. төг/	Төсвийн гүйцэтгэл /сая. төг/		
1	2.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.		2.2.1.1. Дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооны бүтцийг боловсронгуй болгож удирдлага зохион байгуулалтыг сайжруулна.	2021-2024	НБТСГ	Улсын төсөв	4,242.9	Нийслэл, дүүргүүдийн Биеийн тамир, спортын газар, хороодод 63 мэргэжилтэн ажилласан.	Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодын мэргэжилтний тоо 20 хүнээр нэмэгдэж 83 болсон байна.	2,714.2	226.2	2021 онд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын салбарын төв байгууллага Биеийн тамир, спортын улсын хороо нь Засгийн газрын тохируулагч агентлаг болсонтой холбоотойгоор нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод удирдлага, санхүүгийн босоо тогтолцоонд шилжиж салбарын жишиг бүтэц батлагдсан. Баянгол дүүргийн спорт цогцолбор ашиглалтад орсонтой холбогдуулан 2022 онд биеийн тамир, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн орон тоог 21-ээр нэмэгдэж 84 болгосон.	100

												<p>Биеийн тамир, спортын салбарын жишиг бүтцийн дагуу нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороодын албан тушаалын тодорхойлолтын дагуу 2023 онд 229 орон тоотой байхаар батлуулж 2023 оны жилийн эцсийн байдлаар 186 ажилтан, албан хаагч үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан 98 мэргэжилтэн ажиллаж байна. Биеийн тамир, спортын улсын хороотой хамтран 9 дүүргийн спорт хороодын бүтэц, орон тоо, албан тушаалын тодорхойлолтод нягтлан шалгалт хийж, зөвлөмж хүргүүлснээс 7 дүүргийн биеийн тамир, спортын хороодын дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн.</p> <p>Үр дүн: Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодод биеийн тамир, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн 2020 оны суурь түвшнээс 35 хүнээр нэмэгдэж зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн. Салбарын жишиг бүтцийн дагуу хуульд заасан мэргэжил, мэргэшил, ур чадварыг хангасан албан хаагчдыг бүрдүүлэхээр нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---

2		42	2.2.1.2. Дүүргүүдийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болох асуудлыг шийдвэрлүүлнэ	2023- 2024	НБТСГ	Улсын төсөв	230.8	-	Дүүрэг бүрийн нэг хороонд нэг орон тооны арга зүйч нийт 9 арга зүйчтэй болсон байна.	79.9	-	Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах саналыг Биеийн тамир, спортын улсын хороонд 2021 оны 2/73 албан тоотоор, 2022 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэст тус тус 3/235 албан тоотоор, 2023 онд Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороонд 3/225 албан тоотоор, Биеийн тамир, спортын улсын хороонд 3/225 албан тоотоор тус тус хүргүүлсэн. Дээрх санал Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн байна. Тухайн санал “Биеийн тамир, спортын тухай хууль”-д тусгагдсанаар нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх боломж нээгдэнэ. Үр дүн: Хороодод орон тооны арга зүйч ажиллуулах заалт “Биеийн тамир, спортын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын	90
---	--	----	--	---------------	-------	-------------	-------	---	--	------	---	---	----

														Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн байна.	
3			43	2.2.1.3. Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулна.	2021-2024	НБТСТ	1	-	Нийслэлийн хэмжээнд магадлан итгэмжлэлд хамрагдсан 11 спорт клуб байна.	Нийслэлийн хэмжээнд магадлан итгэмжлэлд хамрагдсан спорт клубын тоо 22 болсон байна.	-	-	Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн байна. Спорт клубүүдийг магадлан итгэмжлэлд хамрагдах зөвшөөрлийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос олгодог. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод спорт клубүүдийг сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлэлд хамрагдах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд ороход бэлэн болсон материалуудыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2021 онд 2 спорт клуб магадлан итгэмжлэгдэж нийт 13 спорт клуб болсон. 2022 онд Налайх дүүргийн “Налайх спиннинг” клуб, Сонгинохайрхан дүүргийн “Бумба од” фитнес клубийн материалыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн. 2023 онд 6 спорт клубт арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд орох материалыг бэлтгээд байна. Магадлан итгэмжлэлд хамрагдах болзол хангасан спортын клубийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах эрх зүйн баримт бичиг болох Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалаар	90	

												батлагдсан Спортын клубийн магадлан итгэмжлэх журмын холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан тул Биеийн тамир, спортын салбарт эрхэлсэн сайдын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооноос боловсруулж батлуулах ажлыг хийж байна. Үр дүн: Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 2020 оноос хойш 2 спорт клуб магадлан итгэмжлэгдэж нийт 13 спорт клуб болоод байна. Энэ ажлыг үргэлжлүүлж 2022 онд 2 спорт клуб, 2023 онд 6 спорт клубийг магадлан итгэмжлэлд оруулах материал бэлтгэгдсэн.	
4		44	2.2.1.4. Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж иргэдийн оролцоог	2021-2024	НБТСГ	Нийслэлийн төсөв	1,500.0	Нийтийг хамарсан арга хэмжээнд 315196 иргэд оролцсон.	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчдыг 415,196-д хүргэсэн байна.	Улсын төсвөөс 66.3 Нийслэлийн төсвөөс 710.8	Улсын төсвөөс 47,7 Нийслэлийн төсвөөс 564,8	Нийслэлийн иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлж, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, олон нийтийг хамарсан арга хэмжээнд өргөнөөр хамруулах зорилгоор: 2021 онд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас шалтгаалан 6 арга хэмжээ зохион байгуулж 32.447 иргэнийг хамруулсан 13 цахим сургалтыг 159 удаагийн давтамжтайгаар Нийслэлийн спортын	100

				нэмэгдүүлнэ. /Улаанбаатар марафон, иргэдийн спортын наадам, төрийн албан хаагчдын наадам гэх мэт/								хороо (өмнөх нэрээр)-ны пэйж хуудас болон Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын facebook групп, пэйж хуудаснуудад байршуулан 57.002 иргэнд хүрсэн нь нийслэлийн хүн амын 5.6 хувь болж байна. 2022 онд нийслэл, дүүргийн хэмжээнд 199 арга хэмжээг зохион байгуулж 9563 байгууллагын 441,308 иргэнийг хамруулсан. 2023 онд нийтийг хамарсан 24 арга хэмжээ (“Цасны баяр”, “Өвлийн биеийн тамир, спортын наадам”, “СӨБ”, “ЕБС”-ийн багш, арга зүйчдэд зориулсан багц сургалт, “Цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастик”, “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастик”, “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн биеийн тамирын өдөрлөг”, “Улаанбаатар марафон-2023” олон улсын гүйлт, “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөн, “Иргэдийн спортын наадам”-ын явган алхалт, “Нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын спортын наадам”-ын явган алхалт, “Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”, Нийслэлийн Иргэдийн спортын наадам, Нутгийн захиргааны наадам гэх мэт) зохион байгуулж 2481
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

												байгууллагын 416,000 иргэнийг хамруулсан бол нийслэл, дүүргийн хэмжээнд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 834,000 иргэдийг хамруулсан. Үр дүн: Нийслэлийн иргэдийн дунд нийтийг хамарсан арга хэмжээ, ажил үйлчилгээг 2020 онд 910 удаа зохион байгуулж 315,196 иргэдийг хамруулж байсан бол 2023 онд нийслэлийн хэмжээнд 368 удаа зохион байгуулж 2,481 байгууллагын 416,000 иргэдийг хамруулж хамрагдагчдын тоог 100,804 иргэдээр нэмэгдүүлсэн байна.	
5		45	2.2.1.5. Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлнэ.	2021-2024	НБТСГ	Нийслэлийн төсөв	230.0	Өвлийн улиралд биеийн тамир, спортын арга хэмжээнд 410,000 иргэнийг хамруулсан.	Өвлийн улиралд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдагчид 413,000-д хүрсэн байна.	Нийслэлийн төсвөөс 75.1	Нийслэлийн төсвөөс 56.9	Өвлийн улиралд зохион байгуулагдах биеийн тамир, спортын арга хэмжээнд: 2021 онд "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжаар биеийн тамир, спортын арга хэмжээ хязгаарлагдсан. 2021 онд дүүргүүдийн орон сууц, гэр хорооллын 13 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдан 41600 иргэдэд, "Скай ресорт", "UB Resort", "Хандгайт" "Пара тамирчдын бэлтгэлийн төв" цанын баазууд	100

													<p>байгуулагдан 246,200 иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. 2022 онд 424,972 иргэнийг хамруулсан. 2023 онд өвлийн улиралд зохион байгуулагдах арга хэмжээ, ажил үйлчилгээ, уралдаан тэмцээнд 425,100 иргэд, тамирчдыг хамруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Орон сууц, гэр хорооллын 9 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдан 87000 иргэнд; ➢ Багануур, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн 4 байршил (Мишээл экспо, Хандгайтын Янзага, Скай ресорт, Галуут тур)-д цанын баазууд 152,877 иргэнд ➢ Өвлийн спортын наадмын 5 төрөл (уулын цана, снөүборд, гүйлтийн тэшүүр, хоккей, цана)–д 774 тамирчин бэлтгэл сургуулилтад хамрагдсан. ➢ Нийтийг хамарсан “Цасны баяр” өдөрлөг, арга хэмжээг нийслэл, 9 дүүрэгт 15 удаа зохион байгуулж 13,000 гаруй иргэнийг хамруулсан. ➢ Нийслэлийн Засаг даргын нэрэмжит өвлийн спортын уралдаан, тэмцээнийг 7 төрөл (мөсөн сурын харваа, тэшүүр, гүйлтийн цана, снөүборд, мөсөн авиралт, мөсний шагайн харваа, хоккей)-өөр зохион байгуулж 68 багийн 699 тамирчдыг хамруулсан.
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

													<p>➢ Steppe Arena, Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор, Хүннү мол худалдааны төвүүдэд байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2023 оны 4-р улирлын байдлаар 170,750 иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>Үр дүн: Өвлийн улиралд биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр 2020 онд 410,000 иргэдийг оролцуулж байсан бол 2023 онд 425,100 хүн хамруулжээ.</p>	
6	2.2.2. Нийслэлд үндэсний спорт болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ.		46	2.2.2.1. Багийн спортыг дэмжих замаар есвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.	2021-2024	НБТСГ	Нийслэлийн төсөв	480.0	Багийн спортын төрөлд 145,000 тамирчдыг хамруулсан.	Багийн спортын төрөлд орсон тамирчид 145,200-д хүрсэн байна.	Нийслэлийн төсвөөс 159.8	Нийслэлийн төсвөөс 99,9	<p>Багийн спортын төрлөөр зохион байгуулагдах тэмцээн, уралдаанд: 2021 онд Коронавируст халдвар /"Ковид-19"/-ын тархалттай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжийн биеийн тамир, спортын арга хэмжээ хязгаарлагдсан. Сурагчдад зориулсан биеийн дархлааг дэмжих, дасгал хөдөлгөөний 51 удаагийн цахим дасгалыг "Нийслэлийн спортын хороо" пэйж хуудсанд болон Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын facebook групп болон пэйж хуудаснуудад байршуулан 20.333 хүүхэд, багачуудад хүргэсэн. 2022 онд багийн спортын төрлөөр 8 удаагийн тэмцээнд 1358</p>	100

												<p>багийн 145,200 тамирчдыг хамруулсан. 2023 онд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээн, “Улаанбаатар цом” хөл бөмбөгийн тэмцээн, “Улаанбаатар лиг” волейболын тэмцээн, Монголын хүүхдийн спортын VII наадмын нийслэлийн бүсийн тэмцээнийг багийн спортын 5 төрлөөр тус тус зохион байгуулж 298 байгууллагын 145,350 хүүхэд, багачууд, тамирчид хамрагдсан.</p> <p>Үр дүн: Багийн спортын төрлөөр дамжуулан өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, хүмүүжил олгох, хамтач үзэл санааг төлөвшүүлэн 2020 онд 145,000 хүнийг оролцуулж байсан бол 2023 онд сагсан бөмбөг, хөл бөмбөг, волейбол, гандбол, крикет тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулж 145,350 хүнийг хамруулаад байна.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

7			47	2.2.2.2. Биеийн тамир, спортын төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэлд тулгуурлан спортын уралдаан тэмцээнүүдийн чанар зохион байгуулалтыг сайжруулна.	2021-2024	НБТСГ	Улс, нийслэлийн төсөв	435.0	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд 7096 тамирчин хамрагдсан.	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцогч тамирчдын тоог 7210-т хүргэсэн байна.	Улсын төсвөөс 110.0	Нийслэлийн төсвөөс 73,9 Улсын төсөв 84,6 -	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд: 2021 онд спортын 22 төрлөөр зохион байгуулж 518 байгууллагын 7086 тамирчдыг хамруулсан. 2022 онд спортын 15 төрлөөр зохион байгуулж 446 байгууллагын 7888 тамирчныг хамруулсан. 2023 онд спортын уралдаан тэмцээнийг 30 төрлөөр зохион байгуулахаар төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлж, заавар, журмыг баталсан. Тайлант хугацаанд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Мөсөн сурын харваа, Тэшүүр, Гүйлтийн цана, Снөүборд, Мөсөн авиралт, Мөсний шагайн харваа, Хоккей, Бие хамгаалах урлагийн MGL – 1FC19, Жүдо бөх, Уран сайхны гимнастик, Аэробик гимнастик, Ширээний теннис, Бочи, Хонхтой бөмбөг, Засмал замын дугуй, Спорт авиралт, Үндэсний сур, Спортын гимнастик, Софт теннис, Талбайн теннис, Сумо бөх, Ширээний теннисний ахмадын тэмцээн, бадминтон, пара бадминтон, байт харваа, шатар, виртуал дугуй, “Улаанбаатар цом” хөл бөмбөг, “Улаанбаатар лиг” Сагсан бөмбөг, волейболын шигшээ тэмцээн зэрэг 30 тэмцээнийг зохион	100
---	--	--	----	---	-----------	-------	-----------------------	-------	---	--	---------------------	--	--	-----

													байгуулж 375 багийн 7967 тамирчин оролцсон. Нийслэл, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 199 удаа зохион байгуулж 2720 байгууллагын 156,157 тамирчид оролцсон. Үр дүн: Спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжин ажиллаж 2020 онд Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнүүдэд нийт 7,096 тамирчин хамруулж байсан бол 2023 онд Улаанбаатар хотын аварга шалгаруулах 30 тэмцээнийг зохион байгуулж 7967 тамирчин оролцуулсан. Нийслэл, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 199 удаа зохион байгуулж 156,157 тамирчид оролцсон.	
8		48	2.2.2.3. Олон улсын залуучуудын ногоон наадмыг зохион байгуулна.	2025	НБТСГ	Улс, нийслэлийн төсөв,	28,200.0	-	100%	-	-	Олон улсын Залуучуудын ногоон наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд “Улаанбаатар-2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг зохион байгуулахаар бүтээн байгуулалтын ажлыг 2021 онд 90%, зохион байгуулалтын ажлыг 70% хангаж ажилласан. “Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх цаг үеийн нөхцөл	90	

													байдлаас шалтгаалан “Олон улсын залуучуудын ногоон наадам”-ыг Монгол улсын Засгийн газрын 2021 оны 147 дугаар тогтоолоор 2025 онд зохион байгуулахаар хойшлуулсан. Үр дүн: Олон улсын Залуучуудын ногоон наадмыг Монгол улсын Засгийн газрын 2021 оны 147 дугаар тогтоолоор 2025 онд зохион байгуулахаар хойшлуулсан. Тус наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.	
9		49	2.2.2.4.3үүн Азийн Залуучуудын Анхдугаар наадмыг өндөр түвшинд зохион байгуулна.	2023	НБТСГ	Улс, нийслэлийн төсөв, Төр хувийн хэвшлийн түншлэл	11,200.0	-	100%	-	-	“Улаанбаатар -2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа 11 спортын 12 төрлөөр 2023 оны 08 дугаар сарын 16-наас 23-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус наадмын бэлтгэл ажлын 30%-ийг 2021 онд, 70 хувийг 2022 онд, 2023 онд 100% хангаж ажилласан. Зүүн Азийн олимпын хороо нь есөн үндэсний олимпын хороог өөртөө нэгтгэдэг бөгөөд энэ удаагийн наадамд долоон үндэсний олимпын хорооны 880 тамирчин 8 өдрийн турш ур чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ сорин	100	

												<p>өрсөлдсөнөөс БНХАУ-ын баг, тамирчид 38 алт, 32 мөнгө, 19 хүрэл медаль авч багийн дүнгээр тэргүүлсэн бол Япон улс 22 алт, 7 мөнгө, 13 хүрэл, БНСУ 11 алт, 21 мөнгө, 24 хүрэл, Хятадын Тайвань 11 алт, 10 мөнгө, 21 хүрэл, Монгол улс 3 алт, 13 мөнгө, 28 хүрэл, Хятадын Хонконг 3 алт, 5 мөнгө, 12 хүрэл авсан амжилт үзүүлсэн байна.</p> <p>“Улаанбаатар-2023” Зүүн Азийн Залуучуудын наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг спорт, ёслолын ажиллагаа, наадмын байгууламжууд, байр, сууц, ажиллах хүч, хангамж, тээвэр, мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл, олон улсын харилцаа, протокол, баталгаажилт, бүртгэл, аюулгүй байдал, олон нийттэй харилцах, маркетинг гэсэн 15 чиглэлд хуваан бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллаж амжилттай зохион байгууллаа.</p> <p>Үр дүн: “Улаанбаатар - 2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа зохион байгууллаа.</p>	
10		50	2.2.2.5. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг	2021 - 2024	НБТСГ	Нийс-лэ-лийн төсөв	75.0	Дүүргийн Засаг даргын дэргэд спортын 22 төрлөөр шигшээ баг	Өсвөрийн шигшээ багуудын спортын тоог 24-д хүргэсэн байна.	Орон нутгийн төсвөөс 555.6	Орон нутгийн төсвөөс 579,8	<p>Дүүргийн Засаг даргын дэргэдэх спортын шигшээ багийн төрөлд: 2021 онд спортын 24 төрлөөр 82 дасгалжуулагч, 1814 тамирчин хамрагдсан. 2022</p>	100

				удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлнэ.					хичээллүүлж байна.				<p>онд спортын 3 төрөл (крикет, хоккей, усан спорт)-өөр нэмэгдүүлж 25 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчин хамрагдсан. 2023 онд 9 дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 28 төрлөөр 105 дасгалжуулагч 2944 тамирчдын бүрэлдэхүүнтэйгээр бэлтгэл, сургуулилт, дасгалжуулалтад хамруулсан. Өсвөрийн шигшээ багийн тамирчид тив, дэлхий, олон улс, хот, нэрэмжит 484 тэмцээнд оролцож 1833 медаль хүртсэн амжилт гаргасан байна.</p> <p>Үр дүн: Тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилгоор өсвөрийн шигшээ багийг 2020 онд 22 спортын төрлөөр байгуулж сургалт дасгалжуулалт явуулж байсан бол 2023 онд спортын 28 төрөл болгон өргөжүүлж суурь түвшнээс 6 төрлөөр нэмэгдүүлж үйл ажиллагааг жигдрүүлж бэлтгэл сургуулилт, дасгалжуулалтад хамруулж байна.</p>
--	--	--	--	-------------------------------------	--	--	--	--	--------------------	--	--	--	---

11	2.2.3. Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	51	2.2.3.1. Олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай шинэ цэнгэлдэх хүрээлэнг шинээр барина.	2021-2024	НБТСГ	Улсын төсөв	80,000.0	-	Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	-	-	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрших 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон боловч тухайн газар Байгаль орчны яаманд олгосон газруудтай давхцалтай байсан тул Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот тушаал, Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны 36 тоот тушаалаар дэд ажлын хэсгүүд байгуулагдан газрын маргаан, зөрчлийг шийдвэрлэхээр ажиллаж байгаа ч бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Засгийн газрын 2023 оны 162 дугаар тогтоолоор “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах тухай” Засгийн газрын 2019 оны 315 дугаар тогтоолыг хүчингүй болгосон. Үр дүн: Засгийн газрын 2023 оны 162 дугаар тогтоолоор “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах тухай” Засгийн газрын 2019 оны 315 дугаар тогтоолыг хүчингүй болгосон.	-
----	---	----	--	-----------	-------	-------------	----------	---	---	---	---	--	---

12			52	2.2.3.2. Нийслэл болон Сүхбаатар, Баянзүрх, Налайх, Баянгол, Багахангай дүүргийн спортын 6 цогцолборыг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021- 2024	НБТСТ	Улсын төсөв	10,200.0	Спорт цогцолбор- ын барилга 30-90%-тай хэрэгжиж байна.	Өссөн дүнгээр 5, 2023 онд 2 Спорт цогцолбор ашиглалтад орсон байна.	5,043.6	3,894.0	Нийслэл болон 6 дүүргийн спорт цогцолборыг барих ажил 75 хувь (Чингэлтэй-100%, Баянгол-100%, Налайх -98%, Нийслэл-40%, Сүхбаатар-40%, Баянзүрх-85%, Багахангай-65%)-тай үргэлжилж байна. Үүнээс: 2021 онд Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор ашиглалтад орсон. 2022 онд Баянгол дүүргийн спорт цогцолбор ашиглалтад орж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 2023 онд Баянзүрх, Налайх, Багахангай дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэхээр улсын төсөвт 5,043.6 төгрөг батлагдсан бөгөөд тус 3 цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 82 хувьд хүрсэн. Үүнд: Налайх дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулахаар төлөвлөж улсын төсөвт 1,528.0 сая төгрөг батлагдсанаас 1,300.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч “Бүрд констракшн” ХХК авч нийт ажлын гүйцэтгэл 95 хувьтай байгаа бөгөөд 2023 ондоо багтааж улсын комисст өгөхөөр бэлтгэл ажлыг хангаж байна. Багахангай дүүргийн спорт цогцолборыг “Алтан шар говь” ХХК 2023 онд улсын төсвөөс 294.0 сая төгрөгийн гүйцэтгэл авч нийт ажлын 65 хувийг хийж гүйцэтгээд байна.	90
----	--	--	----	---	---------------	-------	-------------	----------	---	---	---------	---------	--	----

													Баянзүрх спорт цогцолборын гүйцэтгэгч “Атимос трейд” ХХК 2023 онд улсын төсвөөс 2,300.0 төгрөгийн санхүүжилт авч нийт ажлын 85 хувийг хийж гүйцэтгээд байна. Тус спорт цогцолборын ажлыг дуусгахад шаардагдах 2,500.0 сая төгрөгийг 2024 оны улсын төсөвт тусгуулаад байна. Үр дүн: Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор нийслэл болон төвийн 6 дүүрэгт баригдаж байгаа спорт цогцолборуудын барилгын ажлын явц 2020 онд 50 хувьтай хэрэгжиж байсныг үргэлжлүүлж 2023 оны байдлаар Баянгол, Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор тус бүр ашиглалтад орсон бол Налайх, дүүргийн спорт цогцолборын барилгыг энэ онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	
13		53	2.2.3.3. Нийслэлийн дэд төвүүдэд биеийн тамир спортын барилга байгууламж, төрөлжсөн задгай талбайг	2021-2023	НБТСГ		31,635.0	-	Баянхошуу, Дамбадаржаа, Шархад дэд төвийн спорт цогцолборын барилгын ажил дуусна.	-	-	Нийслэлийн дэд төвүүдийн барилга барих ажил: Баянхошуу дэд төвийн спорт цогцолборыг барих худалдан авалтын үйл ажиллагааг 2021 онд “Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нэгж	70	

			төлөвлөх, барих асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.			Гадаадын зээл тус-ламж						зохион байгуулж “Стандарт холдинг” ХХК, “Химон констракшн” ХХК болон “Таны зам” ХХК-ны түншлэл гүйцэтгэгчээр шалгарч Нийслэлийн Засаг даргын тамгын газартай гурвалсан гэрээ байгуулсан. 2022 онд Баянхошуу дэд төвийн спорт цогцолборын 50 хувийг хийж гүйцэтгэсэн. 2023 онд Баянхошуу дэд төвийн 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын гүйцэтгэгч “Стандарт холдинг” ХХК, “Би энд Би” констракшн ХХК болон “Таны зам” ХХК нь барилгын ажлаа үргэлжлүүлж 65%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна. Дамбадаржаа, Шархад дэд төвд тус бүр баригдах спорт цогцолборыг “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутагдалтай байгаа нөхцөлөөс шалтгаалан санхүүжүүлэгч байгууллага болох Азийн хөгжлийн банкны баталсан
--	--	--	--	--	--	------------------------	--	--	--	--	--	---

													төлөвлөгөөнд тусгагдаагүй хасагдсан.	
													<p>Үр дүн: Баянхошуу дэд төвийн 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлын явц 65%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.</p>	
14		54	2.2.3.4.Биеийн тамир, спортын хуучин талбайнуудыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй зөвшилцөн эргүүлэн авах, уг талбайнуудыг нийтийн эдэлбэр газраар үлдээж, сэргээн засна.	2021-2023	НБТСГ	Нийслэлийн төсөв	1,000.0	-	Биеийн тамир, спортын 1 талбайг нийтийн эдэлбэр газар болгож, сэргээн засварлана.	-	-	Нийслэлд биеийн тамир, спортын зориулалтаар ашиглагдаж байгаад иргэд, аж ахуй нэгжид шилжсэн талбайг нийтийн эдэлбэр газраар нь үлдээж, зориулалтын дагуу ашиглах, сэргээн засварлах, дүгнэлт гаргах ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/447 дугаар захирамжаар байгуулж судалгааг бүрэн хийж дуусган үр дүнг 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. 2022 онд Нийслэлийн Хот тохижилтын газарт хүсэлт тавьж Баянзүрх дүүргийн Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын гаднах талбайг талбайг сагсан бөмбөгийн 3х3 төрлийн талбайгаар тохижуулах ажил хийгдсэн. 2023 онд Сонгинохайрхан дүүргийн 40-р хорооны морин	100	

												<p>тойруулгын талбайг сэргээн засах ажлыг гүйцэтгэгч “Стандарт холдинг” ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2023 онд хуучин байгууламжийг нураах ажлыг хийж гүйцэтгээд байна.</p> <p>Үр дүн: 2021 онд бүрэн судалгаа хийгдсэн бол 2022 онд нэг талбайг сэргээн засварласан, 2023 онд Биеийн тамир, спортын зориулалтаар засварлах шаардлагатай 1 талбайг тохижуулах ажлыг хийж байна.</p>	
15		55	<p>2.2.3.5. Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спортын талбайнуудыг стандартын дагуу тохижуулах, аж ахуйн нэгжид олгосныг цуцалж, сургуулийн эзэмшил газарт нь нэмж баталгаажуулна.</p>	2022-2024	НБТСТ	-	-	-	Ерөнхий боловсролын 4 сургуулийн биеийн тамир, спортын талбайг тохижуулна.	-	-	<p>Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамир, спортын гадна талбайн судалгаанд үндэслэн 2021 онд Чингэлтэй дүүргийн 24, 2022 онд Сүхбаатар дүүргийн 2, Хан-Уул дүүргийн 34, 52 дугаар сургуулийн гадна талбайг тухайн дүүрэг тус бүрийн Засаг даргын Тамгын газрын санхүүжилтээр суурийн ажлыг гүйцэтгэн, Монголын Хөл бөмбөгийн холбоотой хамтран олон улсын стандарт шаардлага хангасан хөл бөмбөгийн хиймэл зүлгээр сольж иж бүрэн тохижилт хийсэн. 2023 онд Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 57-р сургууль, Сонгинохайрхан дүүргийн 67-р сургуулийн спорт талбайг хөл бөмбөгийн</p>	100

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Дугаар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Суурь түвшин 2020 он	Зорилтод түвшин 2021 он	Зорилтод түвшин 2022 он	Зорилтод түвшин 2023 он	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8	9	10
2.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.									
41	Биеийн тамир, спортын хороодын мэргэжилтэн	Тоо	НБТСГ	63	Суурь түвшинг хэвээр хадгална.	Суурь түвшинг хэвээр хадгална.	83	Биеийн тамир, спортын хороодын биеийн тамир, спортын үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтний тоог 2020-2023 онд 20 мэргэжилтнээр нэмэгдүүлж 83 болгохоос: 2021 онд МУ-ын Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын салбарын төв байгууллага Биеийн тамир, спортын улсын хороо нь ЗГ-ын тохируулагч агентлаг болсонтой холбоотойгоор нийслэл, дүүргийн БТС-ын хороод удирдлага, санхүүгийн босоо тогтолцоонд шилжиж салбарын жишиг бүтэц батлагдсан. 2022 онд 21-ээр нэмэгдэж 84	100%

								2023 оны 14-өөр нэмэгдэж 98 болж шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн.	
42	Орон тооны биеийн тамирын арга зүйч	Тоо	НБТСГ	-	-	-	9	Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах саналыг Тухайн санал “Биеийн тамир, спортын тухай хууль”-д тусгагдсанаар нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх боломж нээгдэнэ.	90%
43	Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб	Тоо	НБТСГ	11	13	16	22	Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 2020-2023 онд нийт 22 спорт клубыг магадлан итгэмжлэлд хамруулхаар төлөвлөснөөс: 2021 онд 2 спорт клуб 2022 онд Налайх дүүргийн “Налайх спиннинг” клуб, Сонгинохайрхан дүүргийн Бумбод фитнес клубыг материалыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн. 2023 онд 6 спорт клубыг магадлан итгэмжлэлд оруулах материал бэлтгэгдсэн байна. Үр дүн: Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх	90%

								чиглэлээр 2021-2022 онуудад 2 спорт клубыг магадлан итгэмжилсэн бол 2023 онд 6 спорт клубыг магадлан итгэмжлэлд оруулах материал бэлтгэгдсэн.	
44	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчид	Тоо	НБТСГ	315196	347196	362196	415,196	Нийслэлийн хэмжээнд нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагаанд: 2021 онд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас шалтгаалан 6 арга хэмжээ зохион байгуулж 32.447 иргэнийг хамруулсан 13 цахим сургалтыг 159 удаагийн давтамжтайгаар “Нийслэлийн спортын хороо”-ны пэйж хуудас болон Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын facebook групп, пэйж хуудаснуудад байршуулан 57.002 иргэнд хүрсэн нь нийслэлийн хүн амын 5.6 хувьд хүрч ажилласан байна. 2022 онд 19 арга хэмжээг зохион байгуулж 9563 байгууллагын 441,308 иргэнийг хамруулсан. 2023 оны 24 арга хэмжээг зохион байгуулагдаж 416,000 иргэн хамруулснаар шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн.	100%
45	Өвлийн улиралд зохион байгуулагдах биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогчид	Тоо	НБТСГ	410000	411000	412000	413000	Өвлийн улиралд зохион байгуулагдах биеийн тамир, спортын арга хэмжээнд: 2021 онд “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжаар биеийн тамир, спортын арга хэмжээ	100%

								<p>хязгаарлагдсан. 2021 оны I болон IV улиралд дүүргүүдийн орон сууц, гэр хорооллын 13 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдан 41600 иргэдэд, "Скай ресорт", "UB Resort", "Хандгайт" "Пара тамирчдын бэлтгэлийн төв" цанын баазууд байгуулагдан 246,200 иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. 2022 онд 424,972 иргэнийг хамруулсан. 2022 онд 424,972 иргэнийг хамруулсан. 2023 оны 7 төрлөөр 425,100 иргэд, тамирчдыг хамруулснаар шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн.</p>	
2.2.2. Нийслэлд үндэсний спорт болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ.									
46	Багийн спортын төрлөөр зохион байгуулагдах тэмцээн, уралдаанд оролцогч хүүхэд	Тоо	НБТСГ	145000	145100	145150	145,200	<p>Багийн спортын төрлөөр зохион байгуулагдах тэмцээн, уралдаанд: 2021 онд Коронавируст халдвар /"Ковид-19"/-ын тархалттай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжийн биеийн тамир, спортын арга хэмжээ хязгаарлагдсан. Сурагчдад зориулсан биеийн дархлааг дэмжих, дасгал хөдөлгөөний 51 удаагийн цахим дасгалыг "Нийслэлийн спортын хороо" пэйж хуудсанд болон Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын facebook групп болон пэйж хуудаснуудад байршуулан 20.333 хүүхэд, багачуудад хүргэсэн.</p>	100%

								2022 онд багийн спортын төрлөөр 84 удаагийн тэмцээнд 1358 багийн 145,200 тамирчдыг хамруулсан. 2023 онд 145,350 хүүхэд, залуучуудыг хамруулж шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн.	
47	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчид	Тоо	НБТСГ	7096	7134	7172	7210	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд: 2021 онд спортын 34 төрлөөр зохион байгуулж 518 байгууллагын 7086 тамирчдыг хамруулсан. 2022 онд спортын 15 төрлөөр зохион байгуулж 446 байгууллагын 7888 тамирчинг хамруулсан. 2023 онд 30 тэмцээнд 375 багийн 7967 тамирчдыг хамруулж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн.	100%
48	Олон улсын залуучуудын ногоон наадам	Тоо	НБТСГ	-	1	-	-	“Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан “Олон улсын залуучуудын ногоон наадам”-ыг Монгол улсын Засгийн газрын 2021 оны 147 дугаар тогтоолоор 2025 онд зохион байгуулахаар хойшлуулсан. 2021 онд бүтээн байгуулалтын 30% 2022 онд бүтээн байгуулалтын 70% 2023 оны байгуулалтын ажил 90 хувь (хөл бөмбөгийн ногоон талбай бүхий техникийн төв-100%, Спортын ордон /бэлтгэлийн төв/-80%)-тай үргэлжилж байна.	90%

49	Зүүн Азийн Залуучуудын Анхдугаар наадмыг өндөр түвшинд зохион байгуулна.	Хувь	НБТСГ	-	30	70	100	“Улаанбаатар -2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа 11 спортын 12 төрлөөр 2023 оны 08 дугаар сарын 16-наас 23-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулсан.	100%
50	Дүүргийн Засаг даргын дэргэдэх спортын шигшээ багийн төрлийн тоо	Тоо	НБТСГ	22	Суурь түвшинг хэвээр хадгална	23	24	Дүүргийн Засаг даргын дэргэдэх спортын шигшээ багийн төрлийн тоо: 2021 онд спортын 24 төрлөөр 82 дасгалжуулагч, 1814 тамирчин хамрагдсан. 2022 онд спортын 3 төрөл (крикет, хоккей, усан спорт)-өөр нэмэгдүүлж 25 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчин хамрагдсан. 2023 оны нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багуудыг спортын 28 төрлөөр 105 багт 105 дасгалжуулагч 2944 тамирчдын бүрэлдэхүүнтэй сургалт, дасгалжуулалтад хамруулж шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн.	100%
2.2.3. Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.									
51	Олон улсын жишигт нийцсэн 30,000 - 40,000 хүний суудалтай шинэ цэнгэлдэх хүрээлэнгийн	Хувь	НБТСГ	-	ТЭЗҮ боловсруулсан байна.	Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	Гүйцэтгэл 70%-д хүрсэн байна.	Олон улсын жишигт нийцсэн 30000-40000 суудалтай цэнгэлдэх хүрээлэн барих ажлын хүрээнд: 2021 онд Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт	-


	бүтээн байгуулалт							байрших 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон боловч тухайн газар Байгаль орчны яаманд олгосон газруудтай давхцалтай байсан тул Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот тушаал, Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны 36 тоот тушаалаар дэд ажлын хэсгүүд байгуулагдан газрын маргаан, зөрчлийг шийдвэрлэхээр ажиллаж байгаа ч бүрэн шийдвэрлэгдээгүй. 2022 онд “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-гийн зураг төсөв хийх ажлын зардал 2022 оны улсын төсөвт 500.0 төгрөг тусгагдсаны дагуу тус ажлыг гүйцэтгэх байгууллагын жагсаалтыг гаргасан. Засгийн газрын 2023 оны 162 дугаар тогтоолоор “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах тухай” Засгийн газрын 2019 оны 315 дугаар тогтоолыг хүчингүй болгосон тул ажлын гүйцэтгэл 30 хувьтай тасарсан.	
52	Спортын цогцолбор төв	Тоо	НБТСГ	30-90%	1	2	2	Нийслэл болон 6 дүүргийн спорт цогцолборыг барих ажил:2021 онд Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор ашиглалтад орсон. 2022 онд Баян дүүргийн спорт цогцолбор ашиглалтад орж үйл ажиллагаагаа	90%


								<p>эхлүүлсэн. 2023 онд Нийслэл болон 6 дүүргийн спорт цогцолборыг барих ажил 82 хувь (Чингэлтэй-100%, Баянгол-100%, Налайх -95%, Нийслэл-40%, Сүхбаатар-40%, Баянзүрх-85%, Багахангай-65%)-тай үргэлжилж байна.</p> <p>2023 онд Налайх, Баянзүрх дүүргийн спорт цогцолборуудыг ашиглалтад оруулахаар төлөвлөсөнөөс 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Нийслэл, Сүхбаатар дүүргийн спорт цогцолборуудыг барих ажилд 2023 оны улсын төсөвт хөрөнгө суугдаагүй.</p>	
53	<p>Нийслэлийн дэд төвүүдэд биеийн тамир спортын барилга байгууламж, төрөлжсөн задгай талбайг төлөвлөх, барих асуудлаар холбогдох байгууллагуудт ай хамтран ажиллана.</p>	Тоо	НБТСГ	-	Барилгын ажлыг эхлүүлнэ.	1	2	<p>Нийслэлийн дэд төвүүдийн барилга барих ажил:</p> <p>2021 онд худалдан авалтын үйл ажиллагааг “Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн баг зохион байгуулж “Стандарт холдинг” ХХК, “Химон констракшн” ХХК болон “Таны зам” ХХК-иудын түншлэл гүйцэтгэгчээр шалгарч Нийслэлийн Засаг даргын тамгын газартай гурвалсан гэрээ байгуулсан. 2022 онд Баянхошуу дэд төвийн спорт цогцолборын 50 хувийг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2023 онд Баянхошуу дэд төв буюу Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд баригдах 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын гүйцэтгэгч “Стандарт холдинг” ХХК, “Би энд Би”</p>	70%

								<p>контракшн ХХК болон “Таны зам” ХХК-иуд 2023 онд барилгын ажлаа үргэлжлүүлж 65%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна.</p> <p>Шархад дэд төв, буюу Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороонд баригдах 400 хүний суудалтай спорт цогцолборын газрын асуудал шийдэгдэж, зураг төсөл, төсөв бүрэн хийгдсэн боловч хөрөнгийн асуудал шийдэгдээгүйн улмаас Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн ажлын тоо хэмжээнээс хасагдсан.</p>	
54	<p>Биеийн тамир, спортын хуучин талбайнуудыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй зөвшилцөн эргүүлэн авах, уг талбайнуудыг нийтийн эдэлбэр газраар үлдээж, сэргээн засна.</p>	Тоо	НБТСГ	-	Судалгаа хийнэ.	Судалгааг дуусгана.	1	<p>Биеийн тамир, спортын хуучин талбайнуудыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй зөвшилцөн эргүүлэн авах, уг талбайнуудыг нийтийн эдэлбэр газраар үлдээж, сэргээн засах ажил:</p> <p>2021 онд Нийслэлд биеийн тамир, спортын зориулалтаар ашиглагдаж байгаад иргэд, аж ахуй нэгжид шилжсэн талбайг нийтийн эдэлбэр газраар нь үлдээж, зориулалтын дагуу ашиглах, сэргээн засварлах, дүгнэлт гаргах ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/447 дугаар захирамжаар байгуулж судалгааг бүрэн хийж дуусган үр дүнг 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>2022 онд Нийслэлийн Хот тохижилтын газарт хүсэлт тавьж Баянзүрх дүүргийн Хүүхэд</p>	100%

								<p>залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын гаднах талбайг сагсаборын гаднах талбайг сагсан бөмбөгийн 3х3 төрлийн талбайгаар тохижуулах ажил хийгдсэн.</p> <p>Сонгинохайрхан дүүргийн 40-р хорооны морин тойруулгын талбайг сэргээн засах ажлыг гүйцэтгэгч “Стандарт холдинг” ХХК хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>2023 онд Сонгинохайрхан дүүргийн 40-р хорооны морин тойруулгын талбайг сэргээн засах ажлыг гүйцэтгэгч “Стандарт холдинг” ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2023 онд хуучин байгууламжийг нураах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Биеийн тамир, спортын зориулалтаар засварлах шаардлагатай 1 талбайг тохижуулсан.</p>	
55	<p>Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спортын талбайнуудыг стандартын дагуу тохижуулах, аж ахуйн нэгжид олгосныг цуцалж, сургуулийн эзэмшил газарт</p>	Тоо	НБТСГ	-	-	2	2	<p>Нийслэлийн ЕБС-ын биеийн тамир, спортын гадна талбайн 2021 оны судалгаанд үндэслэн:</p> <p>2021 онд ЧД-н 24-р сургууль</p> <p>2022 онд СБД-н 2, ХУД-н 34, 52 дугаар сургуулийн гадна талбайг дүүргийн ЗДТГ-н санхүүжилтийг олгуулж суурийн ажлыг гүйцэтгэн, Монголын Хөл бөмбөгийн холбоотой хамтран ОУ-ын стандарт шаардлага хангасан хөл бөмбөгийн хиймэл зүлгээр сольж иж бүрэн тохижилт хийгдсэн.</p> <p>2023 онд Баянгол дүүргийн Оюуны ундраа сургуулийн гадна талбайг үерийн далан байгуулах ажлыг</p>	100%

НЬ	НЭМЖ баталгаажуулна.						хийсний дараа тохижуулахаар хүлээгдэж байна. Мөн Лантмон ХХК Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газртай гэрээ байгуулан ерөнхий боловсролын 75 дугаар сургуулийн биеийн тамирын гадна талбайг шинэчлэн тохижуулсан. Үр дүн: Ерөнхий боловсролын 4 сургуулийн гадна талбайг 2021-2022 онд иж бүрэн тохижуулах ажил хийгдсэн. 2023 онд 2 сургуулийн талбайг тохижуулсан.	
ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ: Тодорхой үр дүнд хүрсэн								94.6%

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН-БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА  Ж.ГАНБОЛД

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Б.ОЮУНТУЯА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЯНАЛТ–ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Дугаар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Суурь түвшин 2022он	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
2.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.								
1.	41	Биеийн тамир, спортын хороодын мэргэжилтэн	Тоо	НБТСГ	84	83	98	100%
2.	42	Орон тооны биеийн тамирын арга зүйч	Тоо	НБТСГ	Санал хүргүүлсэн	9	Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор 2023 онд 9 арга зүйчтэй болох санал санаачилга гарган “Биеийн тамир, спортын тухай хууль”-д тусгагдсанаар хэрэгжих эхлэх бөгөөд нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх боломж нээгдэнэ. Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	90%

							тухай хуулийн төсөлд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн байгаа бөгөөд зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан гэж үзсэн.	
3.	43	Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб	Тоо	НБТСГ	13	21	Нийт клубын тоо 13 Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 2023 онд 6 спорт клубыг магадланд оруулах материал бэлтгэгдсэн бөгөөд зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан гэж үзсэн.	90%
4.	44	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчид	Тоо	НБТСГ	441,308	415,196	416,000	100%
5.	45	Өвлийн улиралд зохион байгуулагдах биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогчид	Тоо	НБТСГ	416,572	413,000	425,100	100%


2.2.2. Нийслэлд үндэсний спорт болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ.								
6.	46	Багийн спортын төрлөөр зохион байгуулагдах тэмцээн, уралдаанд оролцогч хүүхэд	Тоо	НБТСГ	145,200	145,200	145,350	100%
7.	47	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчид	Тоо	НБТСГ	7,888	7,210	30 тэмцээн 375 баг 7967 тамирчин	100%
8.	48	Олон улсын залуучуудын ногоон наадам	Тоо	НБТСГ	-	-	Олон улсын Залуучуудын ногоон наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахаар бүтээн байгуулалтын ажлыг 90 хувьтай гүйцэтгэж байна. 2025 онд зохион байгуулахаар хойшлогдсон.	90%
9.	49	Зүүн Азийн залуучуудын ногоон наадам	Хувь	НБТСГ	70	100	“Улаанбаатар -2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа зохион байгуулсан.	100%
10.	50	Дүүргийн Засаг даргын дэргэдэх спортын шигшээ баг	Тоо	НБТСГ	24 төрлөөр, 65 баг	24	Спортын 28 төрлөөр, 105 баг	100%
2.2.3. Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.								
11.	51	Олон улсын жишигт нийцсэн 30,000 - 40,000 хүний суудалтай шинэ цэнгэлдэх хүрээлэнгийн бүтээн байгуулалт	Хувь	НБТСГ	30	70	Засгийн газрын 2023 оны 162 дугаар тогтоолоор “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах тухай” Засгийн газрын	-

							2019 оны 315 дугаар тогтоолыг хүчингүй болгосон.	
12.	52	Спортын цогцолбор төв	Тоо	НБТСГ	1	2	(Чингэлтэй-100%, Баянгол-100%, Налайх -95%, Нийслэл-40%, Сүхбаатар-40%, Баянзүрх-85%, Багахангай-65%)	90%
13.	53	Нийслэлийн дэд төвүүдэд биеийн тамир спортын барилга байгууламж, төрөлжсөн задгай талбайг төлөвлөх, барих асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Тоо	НБТСГ	Баянхошуу дэд төвд баригдах спорт цогцолборын барилгын ажлын 50 хувийг гүйцэтгээд байсан бол Шархад дэд төвийн хөрөнгийн асуудал шийдэгдээгүй, Дамбадаржаа дэд төвийн газрын асуудал шийдэгдээгүйн улмаас барилгын ажлууд эхлээгүй.	Дамбаадаржаа Шархад дэд төвийн спорт цогцолборын барилгын ажил дуусна.	Баянхошуу дэд төв буюу Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд баригдах 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын гүйцэтгэгч “Стандарт холдинг” ХХК, “Би энд Би” контрактн ХХК болон “Таны зам” ХХК-иуд 2023 онд барилгын ажлаа үргэлжлүүлж 65%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна.	70%
14.	54	Биеийн тамир, спортын хуучин талбайнуудыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй зөвшилцөн эргүүлэн авах, уг талбайнуудыг нийтийн эдэлбэр газраар үлдээж,	Сэргээн засварласан талбай	НБТСГ	Биеийн тамир, спортын талбайн нэгдсэн тооцооллыг боловсруулсан.	Биеийн тамир, спортын 1 талбайг нийтийн эдэлбэр газар болгож, сэргээн засварлана.	Биеийн тамир, спортын зориулалтаар засварлах шаардлагатай талбайг тохижуулахаар бэлтгэл ажил	1 100%

		сэргээн засна.					хангагдсан.		
15.	55	Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спортын талбайнуудыг стандартын дагуу тохижуулах, аж ахуйн нэгжид олгосныг цуцалж, сургуулийн эзэмшил газарт нь нэмж баталгаажуулна.	Тохижуулсан талбай	НБТСГ	Ерөнхий боловсролын 3 сургуулийн гадна талбайг стандартад нийцсэн хөлбөмбөгийн талбайгаар шинэчлэн тохижуулсан.	ЕБС-иудын биеийн тамир, спортын талбайг тохижуулж, сургуулийн эзэмшил болгоно.	Ерөнхий боловсролын 2 сургуулийн гадна талбайг иж бүрэн тохижуулсан.	100%	
ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ ХУВЬ							94.6%-тай буюу 3 зорилт, 14 арга хэмжээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд тодорхой үр дүнд хүрсэн.		

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА  Ж.ГАНБОЛД

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Б.ОЮУНТУЯА



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН
ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦЭХ ТУХАЙ

Даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн ээлжит хурал 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 13:00 цагаас Нийслэлийн Засаг захиргааны IV байр 7 давхар 707 тоот өрөөнд болж Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд удирдан явуулав.

Хуралд дарга Ж.Ганболд, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг, хурлын нарийн бичгийн даргаар Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн А.Намуун нар оролцлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргасан тайланг хэлэлцэх.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргасан тайланг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяа нар танилцуулав.

СОНССОН НЬ:

Ж.Ганболд: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнд туссан ажлын тайлан түүнд өгсөн үнэлгээг хэлэлцэхээр цугларсан байна. Тайланг хэлтсийн дарга нар хянасан уу шууд эндээ хянахаар байна уу?

Г.Бямбасайхан: Хэлтсүүдээс нэгтгэхэд удирдлагууддаа хянуулсан хувийг авч нэгтгэсэн.

Б.Оюунтуяа: Үнэлгээгээ хэлтсийн дарга нарт танилцуулсан.

Ж.Ганболд: За тайлангаа дэлгэцэд гаргаад үнэлгээгээ давхар хэлэлцээд явъя.

Г.Бямбасайхан: Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 3 зорилтыг хэрэгжүүлэх 15 ажил төлөвлөж жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийг танилцуулж байна. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 11 сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт явцын байдлаар тайлагнасан.

Ж.Ганболд: Хэрэгжилтийг хараад гол гол заалтуудын үнэлгээ дээр санал, хүсэлтээ илэрхийлээд явъя.

С.Саранцэцэг: Дүүргүүдийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болох асуудлыг шийдвэрлүүлнэ гэсэн ажлын гүйцэтгэл хүрэх түвшинд бүрэн хүрээгүй 90 хувьтай үнэлсэн байна манайхаас шалтгаалсан бүх ажлууд бүрэн хийгдсэн тул тайлбарлана уу.

Б.Оюунтуяа: Хороодод орон тооны арга зүйч ажиллуулах заалт “Биеийн тамир, спортын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэгдсэн гэж тайлагнасан байсан. Энэхүү ажил нь Биеийн тамир, спортын хуульд заалт орж батлагдсанаар хэрэгжих боломжтой. Манай байгууллагаас гүйцэтгэх ажлаа бүрэн хийсэн боловч дээд шатны байгууллагуудын хэрэгжүүлэх ажлаас шалтгаалан хэрэгжилт удааширч байгаа тул ингэж үнэлсэн.

М.Цогзолмаа: Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулна гэсэн заалтын биелэлт бас 90 хувьтай үнэлсэн байна. Яаж тайлагнасан талаар тайлбар өгнө үү

Г.Бямбасайхан: Спорт клубүүдийг магадлан итгэмжлэлд хамрагдах зөвшөөрлийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос олгодог. Спортын клубийн магадлан итгэмжлэх журмын холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан тул Биеийн тамир, спортын салбарт эрхэлсэн сайдын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооноос боловсруулж батлуулах ажлыг хийж байгаа ажилтай холбоотойгоор түр хугацаанд зогссон. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагуудын хувьд арга зүйн зөвлөгөө өгч магадлан итгэмжлэлд орох материалыг бэлтгэж дээд шатны байгууллагад хүргүүлэх үүргийг хүлээж ажилладаг. Энэ чиглэлээр 2023 онд 6 спорт клубийн магадлан итгэмжлэлд орох материалыг бэлтгээд байна.

С.Саранцэцэг: Тэгвэл манайх хийх ажлаа бүрэн хэрэгжүүлсэн тул 100 хувь үнэлэх хэрэгтэй гэсэн саналтай байна.

Ж.Ганболд: Энэ үнэлгээ болно. Заалт нь спорт клубийг магадлан итгэмжилсэн байна гэсэн байна.

С.Саранцэцэг: Нийслэлийн дэд төвүүдэд биеийн тамир спортын барилга байгууламж, төрөлжсөн задгай талбайг төлөвлөх, барих асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана гэсэн заалтын хүрэх түвшинд хүрээгүй байгаа тул яаж үнэлсэн бэ тайлбарлана уу

Б.Оюунтуяа: Баянхошуу дэд төвийн 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлын явц 65%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Дамбадаржаа, Шархад дэд төвд тус бүр баригдах спорт цогцолборыг “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутагдалтай байгаа нөхцөлөөс шалтгаалан санхүүжүүлэгч байгууллага болох Азийн хөгжлийн банкны баталсан төлөвлөгөөнд тусгагдаагүй хасагдсан. Энэ 2 спорт цогцолборын хэрэгжээгүй шалгаан нь манай байгууллагын ажлаас шалтгаалаагүй.

Ж.Ганболд: Энэ манай байгууллагаас хэрэгжилт нь бүрэн хамаарахгүй заалтууд тухайлбал 30-40 мянган хүний суудалтай цэнгэлдэх, шинэ дэд төвүүд, орон тооны арга зүйчтэй болох ажлууд үнэлгээнд маш их нөлөөлж байна. Тэгээд манай байгууллагаас шалтгаалах ажлаа бүрэн хийсэн гээд тайлагнахаар нийт ажлын гүйцэтгэл нь бодит биш харагдах гээд их төвөгтэй байна.

Манайхаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт энэ талаар албан тоот явуулж уулзалт хийж байсан. Иймд Олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай шинэ цэнгэлдэх

хүрээлэнг шинээр барина гэсэн заалтыг үнэлэхгүй бусад заалтыг үнэлж тайлагнах саналтай байна.

За өөр хэрэгжилтийн хувьд өөрчлөлт оруулах санал байна уу?

Нэмж тусгах санал гарсангүй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 3 зорилтыг хэрэгжүүлэх 14 ажил төлөвлөж жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн дундаж 94,6 хувьтай тайлагнахаар шийдвэрлэлээ.

2. Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг тодорхойлж бичсэн үг, өгүүлбэрийн утга найруулгыг дахиж нягтлахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяа нарт даалгав.

3. Тайланг Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд нийцүүлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайханд даалгав.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН ДЭРГЭДЭХ УДИРДЛАГЫН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж.ГАНБОЛД

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.БЯМБАСАЙХАН

